ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/292/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Ж.Бямбацогт
Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Релаэнс секюритиз Аудит” ХХК
Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.............................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ............................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ...................................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........................
4. Аудитын тайлан................................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..............................................................................................................
   4.2 Материаллаг байдал ...................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .............................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.................................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/175

танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ЭНХТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 74,4 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

010??383

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **237,059,586.41** | **501,901,540.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 151,644,428.44 | 334,343,803.15 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 151,644,428.44 | 334,343,803.15 |
| **3121** | **Төгрөг** | 151,644,428.44 | 334,343,803.15 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 151,644,428.44 | 334,343,803.15 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 85,415,157.97 | 167,557,737.47 |
| **354** | **Хангамжийн материал** | 81,838,724.13 | 96,531,939.63 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 694,600.00 | 60.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,906,245.32 | 37,465,445.32 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 44,282,409.81 | 52,306,920.31 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 917,969.00 | 1,195,919.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 5,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 37,500.00 | 4,736,095.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 822,000.00 |
| 35600 | Мал амьтад | 3,576,433.84 | 71,025,797.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **973,228,933.50** | **930,320,513.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 973,228,933.50 | 930,320,513.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 933,508,933.50 | 890,600,513.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 945,414,246.25 | 945,414,246.25 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -260,413,425.32 | -302,235,726.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 17,918,800.00 | 14,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -6,802,133.24 | -4,833,333.20 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 279,726,333.97 | 293,519,126.51 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -166,769,163.33 | -160,855,378.75 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 206,307,267.33 | 187,979,721.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -104,144,808.66 | -104,607,958.81 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,520,000.00 | 5,520,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -184,000.00 | -736,000.00 |
| 39217 | Ном | 16,935,816.50 | 16,935,816.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 39,720,000.00 | 39,720,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,010,000.00 | 1,010,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,010,000.00 | -1,010,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,720,000.00 | 39,720,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,210,288,519.91** | **1,432,222,053.81** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,210,288,519.91** | **1,421,015,713.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,210,288,519.91 | 1,421,015,713.81 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 536,197,162.35 | 536,197,162.35 |
| 51101 | Өмч: - төрийн | 536,197,162.35 | 536,197,162.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -101,731,726.52 | 108,995,467.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -101,731,726.52 | -101,731,726.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 210,727,193.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 775,823,084.08 | 775,823,084.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,210,288,519.91** | **1,421,015,713.81** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,428,233,946.50** | **2,014,388,922.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,985,946.50** | **91,639,722.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 21,975,946.50 | 91,639,722.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,975,946.50 | 91,639,722.50 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 7,873,900.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,342,150.00 | 4,368,948.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 20,633,796.50 | 79,396,874.50 |
| **122** | **Тусламжийн орлого** | 10,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,406,248,000.00** | **1,922,749,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,156,030,700.00 | 1,519,918,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,156,030,700.00 | 1,519,918,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 121,892,500.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,892,500.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 128,324,800.00 | 402,831,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 128,324,800.00 | 402,831,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,158,289,085.99** | **1,803,661,728.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,158,289,085.99** | **1,802,754,128.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,070,212,285.99 | 1,802,737,928.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 717,733,194.95 | 1,168,917,027.39 |
| 210101 | Үндсэн цалин | 555,432,752.48 | 882,787,257.89 |
| 210102 | Нэмэгдэл | 151,213,855.32 | 251,220,306.54 |
| 210104 | Урамшуулал | 11,086,587.15 | 34,909,462.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,750,480.20 | 137,823,330.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,629,487.79 | 96,763,358.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,236,422.72 | 10,992,950.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,661,532.36 | 7,233,752.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,481,590.42 | 3,019,354.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,741,446.91 | 19,813,913.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,033,542.83 | 173,054,345.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,730,548.83 | 12,066,776.51 |
| 210302 | Түлш, халаалт | 73,582,994.00 | 155,970,467.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 5,017,102.17 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,335,574.00 | 16,160,590.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 638,690.00 | 11,267,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 2,071,950.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,696,884.00 | 2,821,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 86,449,308.80 | 156,663,515.00 |
| 210502 | Хоол, хүнс | 82,464,400.00 | 149,913,915.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,984,908.80 | 6,749,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,501,838.50 | 12,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,501,838.50 | 12,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 981,424.72 | 8,516,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 613,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 981,424.72 | 7,902,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 82,426,921.99 | 129,602,820.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,327,975.00 | 25,789,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,052,581.20 | 8,616,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 67,046,365.79 | 95,196,820.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 88,076,800.00 | 16,200.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,076,800.00 | 16,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,006,800.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 70,965,700.00 | 16,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,104,300.00 | 00.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **907,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 907,600.00 |
| 220001 | Барилга байгууламж | 00.00 | 907,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **269,944,860.51** | **210,727,193.90** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **269,944,860.51** | **210,727,193.90** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,407,590,150.00** | **1,934,992,048.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,342,150.00** | **12,242,848.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,342,150.00 | 12,242,848.00 |
| 1E+05 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,342,150.00 | 12,242,848.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 7,873,900.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,342,150.00 | 4,368,948.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,406,248,000.00** | **1,922,749,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,156,030,700.00 | 1,519,918,000.00 |
| 1E+05 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,156,030,700.00 | 1,519,918,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 121,892,500.00 | 00.00 |
| 1E+05 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,892,500.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 128,324,800.00 | 402,831,200.00 |
| 1E+05 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 128,324,800.00 | 402,831,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,081,125,804.87** | **1,712,346,040.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,081,125,804.87** | **1,712,346,040.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **993,061,004.87** | **1,637,524,540.95** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 717,733,194.95 | 1,150,910,887.01 |
| 2E+05 | Үндсэн цалин | 555,432,752.48 | 859,215,517.51 |
| 2E+05 | Нэмэгдэл | 151,213,855.32 | 251,220,306.54 |
| 2E+05 | Урамшуулал | 11,086,587.15 | 40,475,062.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,750,480.20 | 143,580,694.08 |
| 2E+05 | Тэтгэврийн даатгал | 61,629,487.79 | 99,435,479.83 |
| 2E+05 | Тэтгэмжийн даатгал | 7,236,422.72 | 12,083,246.58 |
| 2E+05 | ҮОМШӨ-ний даатгал | 5,661,532.36 | 8,265,825.23 |
| 2E+05 | Ажилгүйдлийн даатгал | 1,481,590.42 | 2,186,338.72 |
| 2E+05 | Эрүүл мэндийн даатгал | 13,741,446.91 | 21,609,803.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 76,269,000.00 | 133,107,713.34 |
| 2E+05 | Гэрэл, цахилгаан | 5,713,100.00 | 11,112,744.17 |
| 2E+05 | Түлш, халаалт | 67,922,600.00 | 97,481,550.00 |
| 2E+05 | Цэвэр, бохир ус | 2,633,300.00 | 24,513,419.17 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,231,400.00 | 79,749,010.00 |
| 2E+05 | Хоол, хүнс | 82,231,400.00 | 79,749,010.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 13,000,000.00 |
| 2E+05 | Урсгал засвар | 1,000,000.00 | 13,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 981,424.72 | 8,516,300.00 |
| 2E+05 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 981,424.72 | 7,902,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,095,505.00 | 108,659,936.52 |
| 2E+05 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,548,105.00 | 92,120,036.52 |
| 2E+05 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,547,400.00 | 16,539,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **88,064,800.00** | **74,821,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,064,800.00 | 74,821,500.00 |
| 2E+05 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 74,821,500.00 |
| 2E+05 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,006,800.00 | 00.00 |
| 2E+05 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 76,058,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **326,464,345.13** | **222,646,007.05** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 326,464,345.13 | 222,646,007.05 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 151,644,428.44 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 326,464,345.13 | 334,343,803.15 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 536,197,162.35 | 775,823,084.08 | -206,135,488.32 | 1,105,884,758.11 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **536,197,162.35** | **775,823,084.08** | **-206,135,488.32** | 1,105,884,758.11 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -61,531,541.10 | -61,531,541.10 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **536,197,162.35** | **775,823,084.08** | **-101,731,726.52** | 1,210,288,519.91 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **536,197,162.35** | **775,823,084.08** | **-101,731,726.52** | 1,210,288,519.91 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **536,197,162.35** | **775,823,084.08** | **-101,731,726.52** | 1,210,288,519.91 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 210,727,193.90 | 210,727,193.90 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **536,197,162.35** | **775,823,084.08** | **108,995,467.38** | 1,421,015,713.81 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний ү | - | 151,644,428.44 | (151,644,428.44) | 0 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН Д | 2,223,833,048.00 | 1,654,434,440.95 | 569,398,607.05 | 74.4 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,223,833,048.00 | 1,654,434,440.95 | 569,398,607.05 | 74.4 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 2,113,491,800.00 | 1,579,612,940.95 | 533,878,859.05 | 74.7 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,457,822,200.00 | 1,150,910,887.01 | 306,911,312.99 | 78.9 |
| 6 | Үндсэн цалин | 1,005,749,100.00 | 859,215,517.51 | 146,533,582.49 | 85.4 |
| 7 | Нэмэгдэл | 414,368,200.00 | 251,220,306.54 | 163,147,893.46 | 60.6 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 8,193,500.00 | - | 8,193,500.00 | 0.0 |
| 9 | Урамшуулал | 29,511,400.00 | 40,475,062.96 | (10,963,662.96) | 137.2 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш | 180,860,400.00 | 143,580,694.08 | 37,279,705.92 | 79.4 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 117,251,500.00 | 99,435,479.83 | 17,816,020.17 | 84.8 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 20,004,700.00 | 12,083,246.58 | 7,921,453.42 | 60.4 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 12,346,000.00 | 8,265,825.23 | 4,080,174.77 | 67.0 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 3,443,100.00 | 2,186,338.72 | 1,256,761.28 | 63.5 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 27,815,100.00 | 21,609,803.72 | 6,205,296.28 | 77.7 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зард | 214,957,000.00 | 133,107,713.34 | 81,849,286.66 | 61.9 |
| 18 | Гэрэл цахилгаан | 13,291,700.00 | 11,112,744.17 | 2,178,955.83 | 83.6 |
| 19 | Түлш, халаалт | 194,963,100.00 | 97,481,550.00 | 97,481,550.00 | 50.0 |
| 20 | Цэвэр, бохир ус | 6,702,200.00 | 24,513,419.17 | (17,811,219.17) | 365.8 |
| 30 | Нормативт зардал | 111,892,700.00 | 79,749,010.00 | 32,143,690.00 | 71.3 |
| 32 | Хоол, хүнс | 111,892,700.00 | 79,749,010.00 | 32,143,690.00 | 71.3 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 25,000,000.00 | 13,000,000.00 | 12,000,000.00 | 52.0 |
| 38 | Урсгал засвар | 25,000,000.00 | 13,000,000.00 | 12,000,000.00 | 52.0 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээни | 11,026,600.00 | 8,516,300.00 | 2,510,300.00 | 77.2 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээни | - | 613,900.00 | (613,900.00) | 0.0 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 11,026,600.00 | 7,902,400.00 | 3,124,200.00 | 71.7 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,932,900.00 | 50,748,336.52 | 61,184,563.48 | 45.3 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,123,000.00 | 34,208,436.52 | 52,914,563.48 | 39.3 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,809,900.00 | 16,539,900.00 | 8,270,000.00 | 66.7 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 110,341,248.00 | 74,821,500.00 | 35,519,748.00 | 67.8 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 110,341,248.00 | 74,821,500.00 | 35,519,748.00 | 67.8 |
| 74 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 110,190,600.00 | 74,821,500.00 | 35,369,100.00 | 67.9 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 150,648.00 | - | 150,648.00 | 0.0 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,917,333,048.00 | 1,934,992,048.00 | (17,659,000.00) | 100.9 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 231,846,748.00 | 1,519,918,000.00 | (1,288,071,252.00) | 655.6 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 231,846,748.00 | 1,519,918,000.00 | (1,288,071,252.00) | 655.6 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 98,281,900.00 | 402,831,200.00 | (304,549,300.00) | 409.9 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 98,281,900.00 | 402,831,200.00 | (304,549,300.00) | 409.9 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛА | - | 12,242,848.00 | (12,242,848.00) | 0.0 |
| 111 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүү | - | 7,873,900.00 | (7,873,900.00) | 0.0 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүү | - | 4,368,948.00 | (4,368,948.00) | 0.0 |
| 115 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮ | 1,587,204,400.00 | - | 1,587,204,400.00 | 0.0 |
| 118 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,587,204,400.00 | - | 1,587,204,400.00 | 0.0 |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний ү | - | 151,644,428.44 | (151,644,428.44) | 0.0 |
| 129 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн | - | 334,343,803.15 | (334,343,803.15) | 0.0 |
| 134 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 75.00 | 72.00 | 3.00 | 96.0 |
| 135 | Удирдах ажилтан | 4.00 | 4.00 | - | 100.0 |
| 136 | Гүйцэтгэх ажилтан | 43.00 | 43.00 | - | 100.0 |
| 137 | Үйлчлэх ажилтан | 28.00 | 25.00 | 3.00 | 89.3 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 74,4 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь 75 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 98,3 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,908.4 мянган төгрөгөөр буюу 4% хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 151,644.4 | 334,343.8 | 182,699.3 |
| **Авлага** | | | |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 85,415.1 | 167,557.7 | 82,142.5 |
| **Үндсэн хөрөнгө** | **973,228.9** | **930,320.5** | **-42,908.4** |
| **Нийт хөрөнгө** | **1,210,288.5** | **1,421,015.7** | **210,727.1** |
| **Өр төлбөр** | | | |
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 434,465.5 | 656,399.0 | 221,933.5 |
| **Дахин үнэлгээний зөрүү** | 775,823.0 | 775,823.0 | |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,210,288.5** | **1,421,015.7** | **210,727.1** |

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 182,699.3 мянган төгрөгөөр өссөн нь үдийн цай, хүүхдийн хоолны зардал зэргийг хэмнэснээс мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл байхгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 82,142.5 мянган төгрөгөөр өссөн нь тавилга эд хогшил 1,254.0 мянган төгрөг, сургалтын хэрэглэгдэхүүн 64,449.3 мянган төгрөгийн бараа материал тус тус үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө данс 42,908.4 мянган төгрөгөөр буурсан нь: Сумын ИХТ-н 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09 тоот тогтоолоор 3,418.0 мянган төгрөгийн тээврийн

хэрэгсэл, 35,826.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 20,996.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 60,241.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2.037.501.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 186,331.6 мянган төгрөг нийт зарлагыг 2,223,833.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 2,223,833.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2,223,833.0 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,223,833.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,654,434.4 мянган төгрөг буюу 74,4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 569,398.6 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллыг 306,911.3 мянган төгрөгөөр, даатгалын зардлыг 37,279.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 32,143.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | 71802-Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 4,410.6 | 4,410.6 | | 100% |
| 2 | 80312-Сургалт семинар | 2,510.0 | 2,510.0 | | 100% |
| 3 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 6,429.0 | 4,410.6 | 2,018.4 | 68,6% |
| 4 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 110,190.6 | 74,821.5 | 35,369.1 | 67,9% |
| 5 | 81806- Дотуур байрны үйлчилгээ | 124,284.6 | 79,749.0 | 44,535.9 | 77,4% |
| 6 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 51,573.1 | 51,159.4 | 413.7 | 99,1% |
| 7 | 81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 9,923.9 | 8,180.0 | 1,743.9 | 82,4% |
| 8 | 81827-Бичиг үсгийн боловсрол олгох | 8,050.0 | 8,050.0 | | 100% |
| 9 | 81834- Боловсролын стандарт | 1,189,819.0 | 1,077,347.3 | 112,471.7 | 90,5% |
| 10 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 231,712.7 | 174,142.5 | 57,565.2 | 61,4% |
| 11 | 81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 770.7 | 744.0 | 26.7 | 96,6% |
| 12 | 81848- Сурах бичгийн түрээс | 10,282.0 | 613.9 | 9,668.1 | 5,9% |
| 13 | 83601-нэмэлт санхүүжилт | 7,260.0 | 3,042.0 | 4,218.0 | 42,2% |
| 14 | 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 186,331.6 | 186,331.6 | | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71802-80226 | 2023-12-31 | Байр ашиглалтын үйлчилгээ | 100% | 4,410.6 | 4,410.6 |
| 2 | 71802-80312 | 2023-12-31 | Сургалт семинар | 100% | 2,510.0 | 2,510.0 |
| 3 | 71802-81605 | 2023-12-31 | Эрүүл мэндийг дэмжих | 68,6% | 4,410.6 | 2,018.4 |
| 4 | 71802-81801 | 2023-12-31 | Үдийн цай хөтөлбөр | 67,9% | 74,821.5 | 35,369.1 |
| 5 | 71802-81806 | 2023-12-31 | Дотуур байрны үйлчилгээ | 77,4% | 79,749.0 | 44,535.9 |
| 6 | 71802-81816 | 2023-12-31 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 99,1% | 51,573.1 | 51,159.4 |
| 7 | 71802-81823 | 2023-12-31 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 82,4% | 8,180.0 | 1,743.9 |
| 8 | 71802-81827 | 2023-12-31 | Бичиг үсгийн боловсрол | 100% | 8,050.0 | 8,050.0 |
| 9 | 71802-81834 | 2023-12-31 | Боловсролын стандарт | 90,5% | 1,189,819.0 | 1,077,347.3 |
| 10 | 71802-81835 | 2023-12-31 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 61,4% | 174,142.5 | 57,565.2 |
| 11 | 71802-81844 | 2023-12-31 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 96,6% | 770.7 | 744.0 |
| 12 | 71802-81848 | 2023-12-31 | Сурах бичгийн түрээс | 5,9% | 10,282.0 | 613.9 |
| 13 | 71802-83601 | 2023-12-31 | Нэмэлт төсөв | 42,2% | 7,260.0 | 3,042.0 |
| 14 | 71802- | 2023-12-31 | Төрийн өмчийн | 100% | 186,331.6 | 186,331.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 80111 | | барилгын тогтмол зардал | | | |

Үдийн цай болон дотуур байрны үйлчилгээ хөтөлбөр дутуу хэрэгжсэн нь сурагчдын ирц муу байсан нь нөлөөлсөн. Сурах бичгийн түрээс арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурагчид хувиараа сурах бичгээ худалдан авсантай холбоотой.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс 6 нэр төрлийн 36 ширхэг 49,619.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. Аймгийн Боловсролын газраас тендер шалгаруулсан газруудаас шууд худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,025,000.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 20,500.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,400.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Борнуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна.Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 306,911.3 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 93,849.2 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 32,143.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 157 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгасан болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Акт** | 4 | 2,533.2 | **4** | **2,533.2** | 100% |
| **Албан шаардлага** | | | | | |
| **Зөвлөмж** | 4 | 5,064.8 | 4 | 5,064.8 | 100% |
| **Нийт дүн** | **4** | **7,598.0** | **4** | **7,598.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татхуйц асуудал ажиглагдсангүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс аудитын явцад 1,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

### 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж

1.Өглөгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Урсгал засварт баримтын бүрдэлгүй 1,000.0 мянган төгрөг зарлага гаргасан зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Урсгал засварт баримтын бүрдэлгүй зарлага гаргасан | 1 | 1,000.0 | | | | | 1 | 1,000.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 1,000.0 | | | | | 1 | 1,000.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 159 мэдээ оруулахаас 2 мэдээ хугацаа хоцроосон | 1 | | | | | | 1 | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn